



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25

№

02/50 ЦАГ-САГ/2013/41 СТГА-ТӨҮГ

Улсын төсвийн орлого болгох тухай

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний Төв” ТӨҮГ-ын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил, дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. “Эрчим хүчний хөгжлийн ассоциаци” Төрийн бус байгууллагад 1,398,600 төгрөг хандивласан;
2. Нарийн бичгийн дарга Болормаагийн гадаад хэлний сургалтын төлбөрт ямар нэгэн шийдвэргүйгээр 250,000 төгрөг олгосон;
3. Байгууллагын захирлын тушаалгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр Улсын баяр наадмын билет худалдан авахад болон бэлэг дурсгал, баяр ёслол, уулзалтын үйл ажиллагаанд 2,783,554 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлд заасан “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг”-ийг зөрчсөн байна.

Монгол улсын 2012 оны төсвийн тухай хууль, “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.1 заалтуудыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дээр дурдсан төлбөр, зөрчлийн нийт 4,432,154 төгрөгийг улсын төсвийн орлого болгож, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 900000601 тоот дансанд 2013 оны 4 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэхийг “Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний Төв” ТӨҮГ-ын захирал Б.Алтангэрэл, ерөнхий нягтлан бодогч Н.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.
2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, төлбөрийн актын биелэлтийг 2013 оны 06 дугаар сарын 01-ний дотор гаргаж, Үндэсний Аудитын Газарт ирүүлэхийг “Сэргээгдэх Эрчим Хүчний Үндэсний Төв” ТӨҮГ-ын захирал Б.Алтангэрэл, ерөнхий нягтлан бодогч Н.Эрдэнэчимэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний Аудитын Газрын  
САГ-ын ахлах аудитор

Г.Юра  
“Координат Аудит” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

П.Баярмаа

ЗӨВШӨӨРСӨН

“Сэргээгдэх Эрчим Хүчний  
Үндэсний Төв” ТӨҮГГазрын захирал  
Б.Алтангэрэл  
Ерөнхий нягтлан бодогч

Н.Эрдэнэчимэг



070156